БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

германы хамтын ажиллагаа

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**

17042 Улаанбаатар хот , Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Б.Шаравын гудамж-6, Хан-Уул тауэр, 1201 тоот
Утас: +976-70140166, 70140188,
Э-шуудан: piubaccp@gmail.com,
http://www.baccp.mn

2025.01.08 № 05/01

танай ____________ -ны № ____________-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Үйл ажиллагааны тайланг
хүргүүлэх тухай

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” төслийн 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтын дагуу гарган, хүргүүлж байна.

Хавсралт 33 хуудастай.

ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Д.БАТЦОГТ

УЛААНБААТАР ХОТ
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ
ТБАГ
9020070899 6599737

002501

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын
хавсралт Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
нийтлэг журам

# БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ “БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II/III” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

*(2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)*

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

| Нэр, агуулга | Төслийн нэмэлт тайлбар |
|---|---|
| **Төсөл, хөтөлбөрийн нэр, дугаар** | Төслийн нэр: Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II/III төсөл<br>Төслийн дугаар: BMZ 2016 67 054; BMZ 2018 68 272 |
| **Хөгжлийн түнш/ Санхүүжүүлэгч байгууллага** | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар |
| **Төслийн зорилго, зорилт** | Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/ холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.<br>• Зорилт 1: Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;<br>• Зорилт 2: Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;<br>• Зорилт 3: Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;<br>• Зорилт 4: Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; |
| **Төсөл хэрэгжүүлэгч байгууллага/ Төсөл хэрэгжих хугацаа** | - Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам;<br>- Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: МУ-ын Сангийн яам, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк (*KfW*)<br><br>Хэрэгжих хугацаа: Төслийн 2, 3 дугаар шат 2020 оны 03 дугаар сараас 2027 оны 03 сар хүртэл /II, III үе шат/7 жил |
| **Төсөл, арга хэмжээний** | - ХБНГУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж;<br>- Монгол Улсын Засгийн газар; |

<table>
<tr><td>санхүүжилтийн эх үүсвэр</td><td colspan="3"></td></tr>
<tr><td>Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td colspan="3">Төслийн 2, 3-р шатны нийт хөрөнгийн төсөв 32.8 сая Евро.<br>Үүнээс:<br>- ХБНГУ-ын Засгийн газар 27.5 сая евро;<br>- Монгол Улсын Засгийн Газар 14.8 тэрбум төгрөг;</td></tr>
<tr><td colspan="2">2024 оны батлагдсан төсөв /Төгрөг/</td><td>Санхүүжилтийн гүйцэтгэл /Төгрөг/ (2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)</td><td>2024 оны санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь (%)</td></tr>
<tr><td>ХБНГУ-ын Засгийн газар</td><td>23,477,660,000.00</td><td>13,101,951,692.23</td><td>56</td></tr>
<tr><td rowspan="2">МУ-ын Засгийн газар</td><td>841,300,000.0 /Хөрөнгө оруулалт/</td><td>630,975,000.0</td><td>75</td></tr>
<tr><td>1,167,563,000.00 /Урсгал зардал/</td><td>910,386,816.52</td><td>78</td></tr>
</table>

**“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II/III” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАТЛАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУХ ХЭРЭГЖИЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**<br><br>*Нэгдүгээр зорилтын хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;* | | | |
|---|---|---|---|
| **Төсөл, арга хэмжээний нэр** | **Хэрэгжилт, түүний явц** | **Хэрэгжилтийн хувь** | **Хүрсэн үр дүн** |
| **ҮАТ 1.1**<br>*SMART* программын хэрэглээнд зориулж таблет, ухаалаг гар утас ТХГН-т нийлүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.01-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулсан. Тендерт шалгарсан “Ай Си Ай Систем Монголиа” ХХК-тай 2024 оны 08 дугаар сарын 22-ны гэрээ байгуулсан бөгөөд тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчны хээрийн эргүүл, хяналт шалгалтыг ахисан түвшинд хийх, байгаль хамгааллын мэдээ дата цуглуулан хянаж, удирдах арга зүй бүхий смарт программыг практикт нэвтрүүлж байгаатай уялдуулан хээр хөдөө байгаль цаг уурын янз бүрийн нөхцөлд хяналт мониторинг хийж ажиллах үед нарийвчилсан мэдээ баримт цуглуулах, тэмдэглэх, дамжуулах 556 ширхэг дижитал хэрэгсэл (512 ширхэг ухаалаг гар утас болон 44 ширхэг таблет)-ийг ашиглалт, зааварчилгаа, засвар үйлчилгээ, аюулгүй байдал зэрэг шаардлагатай мэдээлэл агуулсан сургалтыг 40 хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарт зориулан зохион байгуулж, гарын авлагыг Монгол хэл дээр бэлтгэж, бараа бүтээгдэхүүний хамт эцсийн хэрэглэгч 41 байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлгэн өгсөн. | 100 | Төсөлд хамрагдсан ТХГН-ийн мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын байгаль орчны хээрийн эргүүл хяналт мониторингийн мэдээ баримт цуглуулах, цааш цаашдын ажил төлөвлөлтөд ахисан шатанд гаргах, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах ажилд ахиц гарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх ашиглах боломжийг бүрдүүлсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийн санхүүжилт олгогдсон. | | |
| **ҮАТ 1.2**<br>Аймгийн БОАЖГ-уудыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.02-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулсан. Тендерт шалгарсан "Ай Си Ай Систем Монголиа" ХХК-тай 2024 оны 09 дүгээр сарын 27-ны гэрээ байгуулсан бөгөөд хээрийн нөхцөлд ажиллах, судалгаа шинжилгээ, хяналт, мониторинг хийхэд нэн шаардлагатай байгаа 9 нэр төрлийн 2741 тоо ширхэг үндсэн тоног төхөөрөмжийг 16 аймгийн БОАЖГ-уудад хүлээлгэн өгөх ажлыг 2025 оны 01 дүгээр зохион байгуулахаар ажиллаж байна. | 100 | Төсөлд хамрагдсан аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газруудын мэргэжилтэн, албан хаагч, ажилтан, байгаль хамгаалагчдын хээрийн нөхцөлд ажиллах орчин, нөхцөл сайжрах, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах ажилд ахиц гарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээс гадна Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт сайжрах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 1.3**<br>Аймгийн БОАЖГ-уудыг дүрэмт хувцсаар хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.03-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын 16 газар, төслийн зорилтот 17 хамгаалалтын захиргаа, шинээр байгуулагдсан 6 хамгаалалтын захиргаанд дөрвөн улирлын 17 нэр төрлийн нийт 9758 тоо ширхэг барааг 180 хоногт нийлүүлэх гэрээг "Асралтбаян хайрхан" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр байгууллаа. Гэрээний хүрээнд хийгдэх ажлын явц хэвийн явагдаж байна. | **100** | Төсөлд хамрагдсан аймгуудын БОАЖГ, шинээр байгуулагдсан хамгаалалтын захиргаа, төслийн зорилтот хамгаалалтын захиргааны ажилтнуудын хээрийн нөхцөлд ажиллах орчин, нөхцөл сайжирч, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах ажилд ахиц гарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт сайжрах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 1.4**<br>9 ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.04-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр богино хугацааны зөвлөхүүдтэй гэрээ байгуулан 5 | **20** | ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө батлагдсанаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хэрэгжилт тодорхой болж, хамгаалах гэж |

| | | | |
|---|---|---|---|
| | менежментийн төлөвлөгөөг боловсруулж байна. Нийт 9 төлөвлөгөөнөөс 3 төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй (2 ХЗ-ны менежментийн төлөвлөгөөний хугацаа нь дуусаагүй, 1 ХЗ-ний менежментийн төлөвлөгөө /Хомын тал ТББ/-г өөрсдөө боловсруулан хэвлүүлсэн) 5 менежментийн төлөвлөгөөний төслийг богино хугацааны зөвлөхүүдтэй гэрээ байгуулан боловсруулж байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | | бүй ургамал, байгалийн нөөц, биологийн олон янз байдал үнэт зүйлийн менежмент хэрэгжилт сайжрах мөн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн нөөц, бололцоо, хүний нөөц, хуулийн хэрэгжилт хангагдах сайжрах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 1.5**<br>Ойн газар, сумдын ойн ангиудад мониторингийн судалгааны тоног төхөөрөмж нийлүүлж, сургалт явуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.05-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас тус тендерийн Ажлын даалгаврыг дахин шинэчлэх тухай албан бичгийг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Төслийн зөвлөх багт хүргүүлсний дагуу гэж Төслийн зөвлөх баг ажлын даалгаврыг дахин шинэчлэн боловсруулж байна. Тендерийн үнэлгээний хороо 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж дахин зарлах тендерийн баримт бичгийг хэлэлцлээ. Төрийн нарийн бичгийн даргаар тендерийн баримт бичиг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдлаа. KfW-аас 2024 оны 12 дугаар сарын 21-ний өдөр татгалзах зүйлгүй мэдэгдэл ирсэн. Төслийн зөвлөх багийн боловсруулсан Ажлын даалгавар Захиалагчаар батлагдаж ТХН-д ирэхэд | **100** | Ойн салбарын орон нутаг дах мэргэжлийн байгууллага болох сум дундын ойн ангиудын үйл ажиллагааг өргөжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ойжуулалтын орчин үеийн судалгаа, мониторингийн багаж хэрэгсэл, техникээр хангагдсан байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | тус тендерийг 3 дах удаагаа зарлахад бэлэн болсон. | | |
| **ҮАТ 1.6**<br>ТХГН-ийн батлагдсан 5 менежментийн төлөвлөгөө болон төслийн танилцуулга, олон нийтэд зориулсан мэдээллийг боловсруулж хэвлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.06-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалт явуулахгүйгээр Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр зохион байгуулахаар болсны дагуу Говийн бага ДЦГ, Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан Захиалагчид батлуулахаар хүргүүлсэн. Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр брошур, хавтас, фактшитийг англи, монгол хэл дээр нийт 300 ш хэвлүүлсэн хэдий ч үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **50** | ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө батлагдсанаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хэрэгжилт тодорхой болж, хамгаалах гэж буй ургамал, байгалийн нөөц, биологийн олон янз байдал үнэт зүйлийн менежмент хэрэгжилт сайжрах мөн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн нөөц, бололцоо, хүний нөөц, хуулийн хэрэгжилт хангагдах сайжрах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 1.7**<br>Барилгын ажил гүйцэтгэх (бага төсөвт) жишиг баримт бичгийг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.07-д батлагдсан тус төсөл, арга хэмжээ "Барилгын жижиг ажил гүйцэтгэх тендерийн баримт бичиг"-ийн төслийг Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр төслийн зөвлөх багт хүргүүлсэн хэдий ч Төслийн зөвлөх баг барилгын ажил гүйцэтгэх тендерийн баримт бичгийг хянан баталгаажуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэж өгөөгүй байгаа нь Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна.. |
| **ҮАТ 1.8**<br>Төслийн I үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх | **Хэрэгжилт:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 1.08-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт | **100** | Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Архангай аймгийн Цэнхэр сум, Архангай аймгийн Ихтамир сум, Завхан аймгийн Их-Уул сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумдад (i) ОБЭС-ийн хэрэгжүүлэлтийн үр |

| | | | |
|---|---|---|---|
| | шалгарч гэрээ байгуулсан “Эс Ай Си Ай” ХХК-ийн судалгааны багийн эцсийн тайлантай Ажлын хэсэг 2024 оны 06 дугаар 30-ны өдөр хүлээн авч танилцсанаар гэрээний эцсийн санхүүжилтийг олгосон. | | дүн, үр ашгийг үнэлэх; (ii) Өнөөдрийн байдлаар ОБЭС нь төлөвлөсөн болон төлөвлөөгүй ямар үр дүнг бий болгосныг системтэйгээр үнэлэх; (iii) ОБЭС-г өргөжүүлсэн тохиолдолд чадавхыг бэхжүүлэх ажлыг төлөвлөхөд өмнөх сургамжаасаа суралцахын тулд “Техникийн дэмжлэгийн багц”-ын үр ашгийг системтэйгээр үнэлснээр Төслийн 2, 3 дугаар шатанд Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. |

**ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН 8 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ/ БИЕЛЭЛТ:**

- **ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ БАГ /ТЗБ/:** Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгдүгээр зорилтын хүрээнд ТЗБ-ийн хийсэн ажлын хэрэгжилт 47,5 хувийн гүйцэтгэлтэй байна.
  - *ҮАТ 1.1, 1.2, 1.3-д заасан төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг хугацаа хоцроож ирүүлсэн 70%;*
  - *ҮАТ 1.4-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 20%;*
  - *ҮАТ 1.5-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 0%;*
  - *ҮАТ 1.6-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 50%;*
  - *ҮАТ 1.7-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 0%;*
  - *ҮАТ 1.8-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 100%;*

- **ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ /ТХН/**: “Ажлын даалгавар хүлээлцэх хуваарь”-т заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн 4 ажлын даалгаврын дагуу тендер шалгаруулалт явуулж, гэрээ байгуулж, холбогдох сургалтыг зохион байгуулж, он дамжсан болон энэ онд байгуулагдсан гэрээний санхүүжилтийг олгосноор ТХН-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгдүгээр зорилтын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.
  *Тайлбар: Төсөл, арга хэмжээний ажлын даалгавруудыг хугацаа хоцроож ирүүлснээс шалтгаалж ажил хоцрогдолтой хэрэгжсэн. ТХН-ийн зүгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд шаардлага, албан бичиг хүргүүлэн хурал уулзалт зохион байгуулж ажилласан.*

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ “НЭГДҮГЭЭР ЗОРИЛТ”-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 67,6 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**<br>*Хоёрдугаар зорилтын хүрэх үр дүн: Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;* | | | |
|---|---|---|---|
| **Төсөл, арга хэмжээний нэр** | **Хэрэгжилт, түүний явц** | **Хэрэгжилтийн хувь** | **Хүрсэн үр дүн** |
| **ҮАТ 2.01**<br>Хамгаалалтын захиргааны оффисын барилгын хэрэгцээ, шаардлагыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.01, 3.01-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын ажлын даалгавар Захиалагчаар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан хэдий ч Донорын саналыг тусгалгүйгээр Захиалагчаар батлагдсан ажлын даалгавраар тендер зарлахыг хориглосон шийдвэр KfW банкнаас гаргасан тул тус тендер шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй байдал үүссэн байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.02**<br>Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, зардлын тооцоог боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.02, 3.02-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан “Инженеринг суппорт сервис” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний үргэлжлэх хугацааг нэг удаа 60 хоногоор сунгасан. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эхний санхүүжилтийн 40 хувийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | 100 | Монгол орны говь цөлийн, өндөр уулын, ойт хээрийн бүсийн онцлогуудад тохирсон хөдөөгийн алслагдсан газруудад ашиглахад илүү тохиромжтой, ашиглалтын үеийн зардал багатай, ТХГН-ийн сүлжээний хэмжээнд байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл сайжрах нөхцөлийг бүрдүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт сайжрах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. |
| **ҮАТ 2.03**<br>Бусад тээврийн хэрэгслийн (завь, *UTV/ATV*) хэрэгцээ, шаардлагыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.03, 3.03-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч одоог хүртэл эцэслэгдэн Захиалагчид танилцуулагдаагүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| **ҮАТ 2.04** Алсын удирдлагатай камер, нарны зайн хураагуур хэрэгцээ шаардлагыг тодорхойлох | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.04, 3.04-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтаар амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан "Дүйнхэр тэргүүн" ХХК-тай 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээлэгч эхлэлийн тайлан хүлээлгэж өгсний дагуу төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эхний санхүүжилтийн 40 хувийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | **100** | Хэрэгцээ шаардлагын үнэлгээний тайлан хийгдэж, тогтвортой засвар үйлчилгээ хийх боломжуудыг тодорхойлж, техник эдийн засгийн үндэслэл, зөвлөмжүүд боловсруулагдаж, хяналтын камер, нарны зайн эх үүсвэрийг худалдан авах бараа ажил үйлчилгээний ажлын даалгавар боловсруулагдахад шаардлагатай техник эдийн засгийн үзүүлэлтүүд, хяналтын төсөв боловсруулах нөхцөл бүрдсэн. |
| **ҮАТ 2.05** Төслийн II/III үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.05, 3.05-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг ТЗБ боловсруулж эцэслээгүй байгаа нь тендер шалгаруулалт зохион байгуулах нөхцөл бүрдээгүй бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.06** ОБС-гийн үзэл баримтлал, удирдамжийг шинэчлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.06, 3.06-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу богино хугацааны зөвлөх ажиллуулж байгаа хэдий ч орчны бүсийн сангийн үзэл баримтлал, удирдамж шинэчлэгдээгүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.07** ХЗ-ны барилгуудыг шинэчлэх хэрэгцээний судалгаа хийх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.07, 3.07-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу хэрэгцээ шаардлагын үнэлгээг хийсэн хэдий ч *KfW*-ийн хяналт үнэлгээний баг энэ төсөл, арга хэмжээг ХБНГУ-ын хөрөнгө оруулалтаар дэмжихгүй, Монгол Улсын хөрөнгө оруулалтад тооцож болно гэдгээ илэрхийлсэн байгаа бөгөөд энэ төсөл, арга хэмжээг дэмжихгүй гэдэг шийдвэр гаргасан нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | | |
| **ҮАТ 2.08** ТХГН-ийн хамгаалалтын захиргааны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.08, 3.08-д батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь Төслийн 1-р үе шатанд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд үндэслэн гаргах бөгөөд энэхүү төсөл, арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.09** Орчны бүсийн 3 хүртэлх суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.09 3,09-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендерийн ажлын даалгаврыг Төслийн зөвлөх баг боловсруулж, Захиалагчаар батлуулаагүй нь энэхүү ажлыг эхлүүлэх боломжгүй болгосон бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.10** Хан Хөхийн ДЦГ-т ойн загвар төслийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.10-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендерийн ажлын даалгаврыг Төслийн зөвлөх баг боловсруулан Захиалагчаар батлуулаагүй нь энэ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг эхлүүлэх боломжгүй байдалтай байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.11** ТХГН-ийн орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим" байгуулах тавилга, компьютер тоног төхөөрөмжөөр хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.11, 3.10-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан "Хашхан" ХХК-ийн нийлүүлсэн барааг БОАЖЯ /Хуучин нэршлээр/-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс /Хуучин нэршлээр/-т өмч хөрөнгө шилжүүлэн бүртгэл үүсгэсэн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | 100 | Байгаль хамгааллын асуудал нь улс орны тогтвортой хөгжлийн үндэс болоод байгаа энэ цаг үед төслийн зорилтот хэсэг болох өсвөр үеийнхний эх дэлхийнхээ эд эс бүрийг хайрлан хамгаалах сэтгэлтэй байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах дадал зуршил суусан хүнийг бий болгох, экологийн боловсролыг хүүхэд бүрд олгох зорилгын хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн ерөнхий боловсролын 75 сургуульд багаж хэрэгсэл, гарын авлага, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | төхөөрөмжийг нийлүүлснээр хүүхэд сурагчид өөрийн орон нутгийн байгалийн болон соёлын өв, нөөцийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, тэдгээрийг таньж судлах, мэдлэг чадвар олгох нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 2.12** Хамгаалалтын захиргаанд бартаат замын автомашин нийлүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.12, 3.11-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан “Майнс Ап” ХХК-ийн нийлүүлсэн бартаат замын 16 автомашин холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч ашиглалтын болон аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж, гарын авлагыг Монгол хэл дээр бэлтгэж, хамт эцсийн хэрэглэгч 16 байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгө шилжүүлэн бүртгэл үүсгэсэн. | **100** | Орон нутагт байгаль орчны мэргэжлийн байгууллагууд хариуцсан газар нутаг, объектодоо шуурхай хүрч ажиллах боломжийг нэмэгдүүлж, байгаль орчны хяналт шалгалт, судалгаа, мониторингийн хамрах хүрээ, давтамж нэмэгдэж үр нөлөө дээшлүүлэх мөн салбарын хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, байгаль орчны эсрэг зөрчил, гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд ахиц, дэвшил гарах, цаашлаад Тусгай хамгаалалттай бүс нутаг, орчны бүс, эко коридор, усны сав газрын байгалийн төрх, биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайжрах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 2.13** Хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах (UTV, завьнууд, | **Багц 1-ийн хэрэгжилт:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.13, 3.12-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерийн 1 дүгээр | **100** | УТХГН-ийн хамгаалалтын захиргаад, сав газрын захиргаадыг завь, мотоцикл, өөрөө буулгагч автомашин, трактор, |

| | | | |
|---|---|---|---|
| трактор, хогны машин, бохир соруулах машин) | багцад шалгарч гэрээ байгуулсан “Протек” ХХК-ийн нийлүүлсэн барааны ашиглалтын болон аюулгүй байдлын сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр эцсийн хэрэглэгч болох 17 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад зориулан зохион байгуулж, сэлүүрт, жет болон моторт завь, дөрвөн дугуйт мотоциклийг дагалдах хэрэгслийг Монгол хэл дээрх гарын авлагын хамт Захиалагчид хүлээлгэн өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийн санхүүжилт олгогдсон. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэсэн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн.<br><br>**Багц 2-ын хэрэгжилт:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.13-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерийн 2 дугаар багцад шалгарч гэрээ байгуулсан “МБ Инжиниринг” ХХК-ийн нийлүүлсэн өөрөө буулгагч автомашин, трактор, бохир сорох машин чиргүүлийг дагалдах агрегатын хамт 2024 оны 08 дугаар сарын 06-ны Захиалагчид хүлээлгэн өгсөн. Тус бараануудыг хуваарилалтын хүснэгтийн дагуу хүргэн өгч, холбогдох сургалтыг зохион байгуулж, Монгол хэл дээрх гарын авлагын хамт эцсийн хэрэглэгч болох 16 байгууллагад хүлээлгэж өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж байна. | | бохир сорох машин, чиргүүлээр хангаснаар байгаль орчны хяналт шалгалт, судалгаа, мониторингийн хамрах хүрээ, давтамж, үр нөлөө дээшлэх мөн салбарын хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах цаашлаад Тусгай хамгаалалттай бүс нутаг, орчны бүс, эко коридор, усны сав газрын байгалийн төрх, биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайжрах нөхцөлийг сайжруулах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 2.14**<br>ТХГН-ийн орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах ажлын хүрээнд | **Хэрэгжилт:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.14, 3.18-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан “Мөнххада” ХХК-ийн нийлүүлсэн яаралтай түргэн тусламжийн 17 ширхэг автомашиныг ажлын даалгаврын хуваарилалтын хүснэгтийн дагуу ТХГН-ийн орчны бүсийн Эрүүл мэндийн төвүүдэд Монгол хэл дээрх гарын авлагын хамт | **100** | Энэхүү төсөл, арга хэмжээнд сонгогдсон ТХГН-ийн Орчны бүсийн 17 сумд нь алслагдмал, хүн ам нь таруу байршсан, мөн түүнчлэн эмнэлгийн яаралтай тусламжийн автомашингүй сумууд байсан. Эмнэлгийн анхан шатны тусламж, |

| | | | |
|---|---|---|---|
| | хүлээлгэн өгч, холбогдох сургалтыг зохион байгууллаа. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж байна. | | үйлчилгээг шуурхай үзүүлснээс өвчтөний амь нас, цаашдын эрүүл мэндийн байдал шууд хамаардаг учраас эмнэлгийн яаралтай тусламжийн автомашингүй байсан ТХГН-ийн Орчны бүсийн 17 сумдыг сонгон яаралтай тусламжийн багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон бартаат замын автомашинаар хангасан. Тус сумдад амьдарч буй 56,000 гаруй иргэдийн эмнэлгийн анхан шатны яаралтай тусламжийг цаг алдалгүй авч, олон улсын жишигт нийцсэн тоног төхөөрөмжөөр анхан шатны эмчилгээ үйлчилгээ нийлгэх нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 2.15** ТХГН-ийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах | **Хэрэгжилт:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.15, 3.14-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан "Протек" ХХК-ийн нийлүүлсэн 200ш мотоцикл дагалдах хэрэгслийн хамт 2024 оны 08 дугаар сарын 06-ны Захиалагчид хүлээлгэн өгсөн. Тус барааг хуваарилалтын хүснэгтийн дагуу хүргэн өгч, холбогдох сургалтыг зохион байгуулж, Монгол хэл дээрх гарын авлагын хамт эцсийн хэрэглэгч болох<br>20 байгууллагад хүлээлгэж өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж байна. хэрэглэгч болох 20 байгууллагад хүлээлгэж өгсөн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж | **100** | УТХГН-ийн хамгаалалтын захиргаад туулах чадвар сайтай мотоциклоор хангагдсанаар хариуцсан газар нутагтаа хүрч ажиллах боломж нөхцөл сайжирч, салбарын хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, зөрчлийн тоо буурах, таслан зогсооход ахиц гарах, мөн түүнчлэн биологийн олон янз байдлын судалгаа, мониторингийн давтамж сайжирч био техникийн арга хэмжээний цар хүрээ нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | байна. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | | |
| **ҮАТ 2.16** Цаг уурын автомат станцаар хангах (Говь-Алтай-2, Ховд-2) | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.16-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан "АЧСВС" ХХК-тай 2024 оны 09 дүгээр сарын 27-ны гэрээ байгуулсан бөгөөд нийлүүлэх 4 ширхэг цаг уурын автомат станцыг Ховд, Говь-Алтай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд хүргэж, хүлээлгэн өгөх ажлыг 2025 оны 01 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хэрэгжилт 100% | **100** | Ард иргэдийг цаг агаарын мэдээллээр хангах, зарлан мэдээлэх, байгалийн гамшигт үзэгдлээс сэргийлэх, сөрөг үр дагаврыг бууруулах чадавх сайжрах, бэлчээрийн талхагдал, доройтол, хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын зүйлийн бүрдлийг тооцож гаргах, байгаль орчны ажиглалт мониторингийн ажлын чанар дээшлэх, мөн түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 2.17** Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилгын одоогийн зураг төсөл, зардлын тооцоог шинэчлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.17-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ оны 01 дүгээр сарын 16-ны өдөр "Бьюлдингс технологи" ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Гэрээ байгуулсан -ийн ирүүлсэн эхлэлийн тайлан /барилгын эскиз зураг/-г Захиалагч баталсан. Гэрээг 90 хоногоор нэг удаа сунгасан. Барилгын зураг төсөв KfW болон Барилгын хөгжлийн төвөөр шинэчилсэн зураг төсөл, төсвийг батлуулаагүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **100** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.18** Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих (худаг) | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.18-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын Ажлын даалгавар, "Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих (худаг)"-ийн зураг төсөл, төсөв нь KfW, Барилга хөгжлийн төвөөр батлагдаагүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| **ҮАТ 2.19** Байгаль хамгаалагчийн 12 байр барих | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.19, 3.15-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын Ажлын даалгавар, Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, төсөв нь Барилга хөгжлийн төвөөр батлагдаагүй нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.20** Баруун бүсийн хог хаягдлын менежментийн хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.20-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу GIZ-SPACES хамтран ажиллаж хэрэгцээ шаардлагын үндэслэл болон хогны менежментийн төслийг 2024 оны 7 сарын 4-нд хүлээн авсан. Одоогоор Төслийн зөвлөх баг хэрэгцээ шаардлагын үнэлгээний шинэчилсэн хувилбарыг гаргахаар ажиллаж байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүн хүрч хэрэгжээгүй байна. | **50** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 2.21** Хяргас нуурын БЦГ-ын орчны бүсэд бирвааз барих хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.21-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан “Дөрвөн тэнхлэг” ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээлэгчийн ирүүлсэн эхлэлийн тайлан Захиалагчаар хянагдаж байна. Хэрэгжилт 100% | **100** | Үр дүн: Хяргас нуур, Айраг нуурыг холбодог хоолойг гатлах байгууламж хэрэгслийг сайжруулах талаарх хувилбарт санал, түүнийг тогтвортой ашиглах, засвар үйлчилгээ хийх боломжуудыг тодорхойлж, эдийн засгийн тооцооллуул |

**ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН 21 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ/ БИЕЛЭЛТ**

- **ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ БАГ /ТЗБ/:** Үйл ажиллагааны төлөвлөгөөний хоёрдугаар зорилтын хүрээнд ТЗБ-ийн хийсэн ажлын хэрэгжилт 41,9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:
  - *ҮАТ 2.1, 2.3, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.17, 2.18, 2.19,-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 0%;*
  - *ҮАТ 2.20-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 50%;*
  - *ҮАТ 2.2, 2.4, 2.16 болон 2.21-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70%;*
  - *ҮАТ 2.11, 2.12, 2.13, 2.14, болон 2.15-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 100%;*
- **ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ /ТХН/**: "Ажлын даалгавар хүлээлцэх хуваарь"-д заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн 4 ажлын даалгаврын дагуу тендер шалгаруулалтыг явуулж, гэрээ байгуулж, мөн холбогдох сургалтыг зохион байгуулж, он дамжсан болон энэ онд байгуулагдсан гэрээний санхүүжилтийг олгосноор ТХН-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хоёрдугаар зорилтын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. *Тайлбар: Төсөл, арга хэмжээний ажлын даалгавруудыг хугацаа хоцроож ирүүлснээс шалтгаалж ажил хоцрогдолтой хэрэгжсэн. Мөн ажлын даалгаврыг огт ирүүлээгүй нь тендер шалгаруулалтыг эхлүүлэх боломжгүй болгосон. ТХН-ийн зүгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд шаардлага, албан бичиг хүргүүлэн хурал уулзалт зохион байгуулж ажилласан.*

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ "ХОЁРДУГААР ЗОРИЛТ"-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 60,6 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

*Хүрэх үр дүн: Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;*

| Төсөл, арга хэмжээний нэр | Хэрэгжилт, түүний явц | Хэрэгжилтийн хувь | Хүрсэн үр дүн |
|---|---|---|---|
| **ҮАТ 3.01** Хамгаалалтын захиргааны оффисын барилгын хэрэгцээ, шаардлагыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.01, 3.01-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын ажлын даалгавар Захиалагчаар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан хэдий ч Донорын саналыг тусгалгүйгээр Захиалагчаар батлагдсан ажлын даалгавраар тендер зарлахыг хориглосон шийдвэр KfW банкнаас гаргасан тул тус тендер шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй байдал үүссэн байгаа нь үйл ажиллагааны | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | төлөвлөгөөнд заасан хүрэх дунд хүрч хэрэгжээгүй байна. | | |
| **ҮАТ 3.02** Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, зардлын тооцоог боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.02, 3.02-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан "Инженеринг суппорт сервис" ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний үргэлжлэх хугацааг нэг удаа 60 хоногоор сунгасан. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эхний санхүүжилтийн 40 хувийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | **100** | Монгол орны говь цөлийн, өндөр уулын, ойт хээрийн бүсийн онцлогуудад тохирсон хөдөөгийн алслагдсан газруудад ашиглахад илүү тохиромжтой, ашиглалтын үеийн зардал багатай, ТХГН-ийн сүлжээний хэмжээнд байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл сайжрах нөхцөлийг бүрдүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт сайжрах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 3.03** Бусад тээврийн хэрэгслийн (завь, UTV / ATV) хэрэгцээ, шаардлагыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.03, 3.03-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч одоог хүртэл эцэслэгдэн Захиалагчид танилцуулагдаагүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дунд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дунд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 3.04** Алсын удирдлагатай камер, нарны зайн хураагуур хэрэгцээ шаардлагыг тодорхойлох | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.04, 3.04-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтаар амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан "Дүйнхэр тэргүүн" ХХК-тай 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр гэрээ байгуулсан.Гэрээлэгч эхлэлийн тайлан хүлээлгэж өгсний дагуу төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эхний санхүүжилтийн 40 хувийг хувийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | **100** | Хэрэгцээ шаардлагын үнэлгээний тайлан хийгдэж, тогтвортой засвар үйлчилгээ хийх боломжуудыг тодорхойлж, техник эдийн засгийн үндэслэл, зөвлөмжүүд боловсруулагдаж, хяналтын камер, нарны зайн эх үүсвэрийг худалдан авах бараа ажил үйлчилгээний ажлын даалгавар боловсруулагдахад шаардлагатай техник эдийн засгийн үзүүлэлтүүд, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хяналтын төсөв боловсруулах нөхцөл бүрдсэн. |
| **ҮАТ 3.05**<br>Төслийн II/III үе шатны ОБЗЭС-ийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.05, 3.05-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг ТЗБ боловсруулж эцэслээгүй байгаа нь тендер шалгаруулалт зохион байгуулах нөхцөл бүрдээгүй бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 3.06**<br>ОБС-гийн үзэл баримтлал, удирдамжийг шинэчлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.06, 3.06-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу богино хугацааны зөвлөх ажиллуулж байгаа хэдий ч орчны бүсийн сангийн үзэл баримтлал, удирдамж шинэчлэгдээгүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 3.07**<br>ХЗ-ны барилгуудыг шинэчлэх хэрэгцээний судалгаа хийх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.07, 3.07-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу хэрэгцээ шаардлагын үнэлгээг хийсэн хэдий ч *KfW*-ийн хяналт үнэлгээний баг энэ төсөл, арга хэмжээг ХБНГУ-ын хөрөнгө оруулалтаар дэмжихгүй, Монгол Улсын хөрөнгө оруулалтад тооцож болно гэдгээ илэрхийлсэн байгаа бөгөөд энэ төсөл, арга хэмжээг дэмжихгүй гэдэг шийдвэр гаргасан нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 3.08**<br>ТХГН-ийн ХЗ-ны ОБЗЭС-ийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.08, 3.08-д батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь Төслийн 1-р үе шатанд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд үндэслэн гаргах бөгөөд энэхүү төсөл, арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| **ҮАТ 3.09**<br>Монгол элсний БЦГ-т ойн загвар төслийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 3.09-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг Төслийн зөвлөх баг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч одоог хүртэл эцэслэгдэн Захиалагчид танилцуулагдаагүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 3.10**<br>ТХГН-ийн орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим" байгуулах тавилга, компьютер тоног төхөөрөмжөөр хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.11, 3.10-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан "Хашхан" ХХК-ийн нийлүүлсэн барааг БОАЖЯ /Хуучин нэршлээр/-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс /Хуучин нэршлээр/-т өмч хөрөнгө шилжүүлэн бүртгэл үүсгэсэн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | **100** | Байгаль хамгааллын асуудал нь улс орны тогтвортой хөгжлийн үндэс болоод байгаа энэ цаг үед төслийн зорилтот хэсэг болох өсвөр үеийнхний эх дэлхийнхээ эд эс бүрийг хайрлан хамгаалах сэтгэлтэй байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах дадал зуршил суусан хүнийг бий болгох, экологийн боловсролыг хүүхэд бүрд олгох зорилгын хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн ерөнхий боловсролын 75 сургуульд багаж хэрэгсэл, гарын авлага, сургалтын материалаар ханган, шаардлагатай тавилга, IT тоног төхөөрөмжийг нийлүүлснээр хүүхэд сурагчид өөрийн орон нутгийн байгалийн болон соёлын өв, нөөцийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, тэдгээрийг таньж судлах, мэдлэг чадвар олгох нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 3.11**<br>Хамгаалалтын захиргаанд | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.12, 3.11-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер | **100** | Орон нутагт байгаль орчны мэргэжлийн байгууллагууд |

| | | | |
|---|---|---|---|
| бартаат замын автомашин нийлүүлэх | шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан “Майнс Ап” ХХК-ийн нийлүүлсэн бартаат замын 16 автомашин холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч ашиглалтын болон аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж, гарын авлагыг Монгол хэл дээр бэлтгэж, хамт эцсийн хэрэглэгч 16 байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийн санхүүжилт олгогдсон. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгө шилжүүлэн бүртгэл үүсгэсэн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | | хариуцсан газар нутаг, объектодоо шуурхай хүрч ажиллах боломжийг нэмэгдүүлж, байгаль орчны хяналт шалгалт, судалгаа, мониторингийн хамрах хүрээ, давтамж нэмэгдэж үр нөлөө дээшлүүлэх мөн салбарын хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, байгаль орчны эсрэг зөрчил, гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд ахиц, дэвшил гарах, цаашлаад Тусгай хамгаалалттай бүс нутаг, орчны бүс, эко коридор, усны сав газрын байгалийн төрх, биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайжрах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 3.12**<br>Сонгогдсон 7 хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах | **Багц 1:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.13, 3.12-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерийн 1 дүгээр багцад шалгарч гэрээ байгуулсан “Протек” ХХК-ийн нийлүүлсэн барааны ашиглалтын болон аюулгүй байдлын сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр эцсийн хэрэглэгч болох 17 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад зориулан зохион байгуулж, сэлүүрт, жет болон моторт завь, дөрвөн дугуйт мотоциклийг дагалдах хэрэгслийг Монгол хэл дээрх гарын авлагын хамт Захиалагчид хүлээлгэн өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийн | **100** | УТХГН-ийн хамгаалалтын захиргаад, сав газрын захиргаадыг завь, мотоцикл, өөрөө буулгагч автомашин, трактор, бохир сорох машин, чиргүүлээр хангаснаар байгаль орчны хяналт шалгалт, судалгаа, мониторингийн хамрах хүрээ, давтамж, үр нөлөө дээшлэх мөн салбарын хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах цаашлаад Тусгай хамгаалалттай бүс |

| | | | |
|---|---|---|---|
| | санхүүжилт олгогдсон. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэсэн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн.<br><br>**Багц 2:** Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.13-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерийн 2 дугаар багцад шалгарч гэрээ байгуулсан "МБ Инжиниринг" ХХК-ийн нийлүүлсэн өөрөө буулгагч автомашин, трактор, бохир сорох машин чиргүүлийг дагалдах агрегатын хамт 2024 оны 08 дугаар сарын 06- ны Захиалагчид хүлээлгэн өгсөн.Тус бараануудыг хуваарилалтын хүснэгтийн дагуу хүргэн өгч, холбогдох сургалтыг зохион байгуулж, Монгол хэл дээрх гарын авлагын хамт эцсийн хэрэглэгч болох 16 байгууллагад хүлээлгэж өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж байна. | | нутаг, орчны бүс, эко коридор, усны сав газрын байгалийн төрх биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайжрах нөхцөлийг сайжруулах боломжийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 3.13**<br>ТХГН-ийн орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.14, 3.18-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан "Мөнххада" ХХК-ийн нийлүүлсэн яаралтай түргэн тусламжийн 17 ширхэг автомашиныг ажлын даалгаврын хуваарилалтын хүснэгтийн дагуу ТХГН-ийн орчны бүсийн Эрүүл мэндийн төвүүдэд Монгол хэл дээрх гарын авлагын хамт хүлээлгэн өгч, холбогдох сургалтыг зохион байгууллаа. | 100 | Энэхүү төсөл, арга хэмжээнд сонгогдсон ТХГН-ийн Орчны бүсийн 17 сумд нь алслагдмал, хүн ам нь тарүү байршсан, мөн түүнчлэн эмнэлгийн яаралтай тусламжийн автомашингүй сумууд байсан. Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчилгээг шуурхай үзүүлснээс өвчтөний амь нас, цаашдын эрүүл мэндийн байдал шууд хамаардаг учраас эмнэлгийн яаралтай тусламжийн |

| | | | |
|---|---|---|---|
| | Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж байна. | | автомашингүй байсан ТХГН-ийн Орчны бүсийн 17 сумдыг сонгон яаралтай тусламжийн багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон бартаат замын автомашинаар хангасан. Тус сумдад амьдарч буй 56,000 гаруй иргэдийн эмнэлгийн анхан шатны яаралтай тусламжийг цаг алдалгүй авч, олон улсын жишигт нийцсэн тоног төхөөрөмжөөр анхан шатны эмчилгээ үйлчилгээ нийлгэх нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 3.14** ТХГН-ийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.15, 3.14-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан "Протек" ХХК-ийн нийлүүлсэн 200ш мотоцикл дагалдах хэрэгслийн хамт 2024 оны 08 дугаар сарын 06-ны Захиалагчид хүлээлгэн өгсөн. Тус барааг хуваарилалтын хүснэгтийн дагуу хүргэн өгч, холбогдох сургалтыг зохион байгуулж, Монгол хэл дээрх гарын авлагын хамт эцсийн хэрэглэгч болох 20 байгууллагад хүлээлгэж өгсөн. Төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэхээр ажиллаж байна. | **100** | УТХГН-ийн хамгаалалтын захиргаад туулах чадвар сайтай мотоциклоор хангагдсанаар хариуцсан газар нутагтаа хүрч ажиллах боломж нөхцөл сайжирч, салбарын хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, зөрчлийн тоо буурах, таслан зогсооход ахиц гарах, мөн түүнчлэн биологийн олон янз байдлын судалгаа, мониторингийн давтамж сайжирч био техникийн арга хэмжээний цар хүрээ нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| **ҮАТ 3.15** Байгаль хамгаалагчийн 12 байр барих | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 2.19, 3.15-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын Ажлын даалгавар, Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, төсөв нь Барилга хөгжлийн төвөөр батлагдаагүй нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **100** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |

**ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН 15 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ/ БИЕЛЭЛТ**

- **ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ БАГ /ТЗБ/:** Үйл ажиллагааны төлөвлөгөөний гуравдугаар зорилтын хүрээнд ТЗБ-ийн хийсэн ажлын хэрэгжилт **42,6** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:
- *ҮАТ 3.1, 3.3, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9 болон 3.10-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 0%;*
- *ҮАТ 3.2, 3.4-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70%;*
- *ҮАТ 3.11, 3.12, 3.13, 3.14 болон 3.15-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 100%;*

- **ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ /ТХН/:** "Ажлын даалгавар хүлээлцэх хуваарь"-ийн төлөвлөсөн хугацаанаас хоцроож ирүүлсэн 2 ажлын даалгаврын дагуу тендер шалгаруулалтыг явуулж, гэрээ байгуулж, холбогдох сургалтын зохион байгуулж, он дамжсан болон энэ онд байгуулагдсан гэрээний санхүүжилтийг олгосноор гуравдугаар зорилтын хэрэгжилт **100** хувийн гүйцэтгэлтэй байна.
  *Тайлбар: Төсөл, арга хэмжээний ажлын даалгавруудыг хугацаа хоцроож ирүүлснээс шалтгаалж ажил хоцрогдолтой хэрэгжсэн. Мөн ажлын даалгаврыг огт ирүүлээгүй нь тендер шалгаруулалтыг эхлүүлэх боломжгүй болгосон. ТХН-ийн зүгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд шаардлага, албан бичиг хүргүүлэн хурал уулзалт зохион байгуулж ажилласан.*

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ "ГУРАВДУГААР ЗОРИЛТ"-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 60,9 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

*Дөрөвдүгээр зорилтын хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;*

| Төсөл, арга хэмжээний нэр | Хэрэгжилт, түүний явц | Хэрэгжилтийн хувь | Хүрсэн үр дүн |
|---|---|---|---|
| **ҮАТ 4.1** Үндэсний чуулган зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.1-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулах тов | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд |

| | | | |
|---|---|---|---|
| | Захиалагчаас гарсны дагуу Төслийн захирлаас "Байгаль хамгаалагчийн үндэсний чуулган" зохион байгуулах өгсөн чиглэлийн дагуу энэхүү ажил үргэлжилж байна. | | хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 4.2**<br>ТХГН-ийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, стандарт боловсруулах уулзалт зөвлөгөөн зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.2-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний хүрээнд "Төслийн санхүүжилтээр ТХГН-ын ХЗ-д олгосон техник, тоног төхөөрөмж, хөрөнгийн ашиглалт, эзэмшлийг сайжруулахад шаардлагатай дүрэм, журам, стандартыг боловсруулах" зөвлөгөөнийг Архангай аймгийн Цэцэрлэг хотод 2024 оны 10 дугаар сарын 02-ноос 04-ны өдрүүдэд, Хэнтий аймгийн Дадал суманд 2024 оны 10 дугаар сарын 07-ноос 09-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан. | **100** | БОУАӨЯ-ны зүгээс төслөөс олгосон хөрөнгийн ашиглалттай холбоотой дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлэхээр тогтсон. Мөн төслөөс олгосон техник, тоног төхөөрөмж, хөрөнгийн ашиглалт, эзэмшлийг сайжруулах, ашиглалтын болон урсгал зардлыг тооцон, ашиглалтын жилүүдэд нь бүрэн ашиглах талаарх зөвлөгөөнд ТХГН-ийн 31 хамгаалалтын захиргааг төлөөлж ирсэн дарга, нягтлан бодогч, судалгаа шинжилгээ, мэдээллийн сан хариуцсан 90 хүн оролцож, хэлэлцүүлэг өрнүүлснээр бүх оролцогчид төслөөс олгосон хөрөнгийн ашиглалтын талаар нэгдсэн нэг ойлголтод хүргэх зорилго хангагдлаа. |
| **ҮАТ 4.03**<br>ТХГН-ийн чадавхыг хөгжүүлэх зорилгоор зорилтод бүлгүүдэд шаардлагатай сургалтын үзэл баримтлалыг боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.2-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний хүрээнд Төслийн зөвлөх баг гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч одоог хүртэл эцэслэгдэн Захиалагчид танилцуулагдаагүй байгаа нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | **0** | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 4.04**<br>Байгаль хамгаалагчийн сургалтын | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.4-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтаар амжилттай зохион байгуулсан. Тендерт | **100** | Байгаль орчин, аялал жуулчлал /Хуучин нэршлээр/-ын сайдын 2024 оны 03 дугаар сарын 29- |

| | | | |
|---|---|---|---|
| хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах | шалгарсан "Дэлгэр консалтинг" ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 10-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээлэгч эхлэлийн тайлан хүлээлгэж өгснөөр төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эхний санхүүжилтийн 40 хувийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | | ний өдрийн А/189 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр"-ийн анхан болон дунд шатны сургалтын модуль материал гарч, байгаль хамгаалагчид сургалтад хамруулах нөхцөлийг бүрдүүлсэн. ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 4.05** Төслийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх контент боловсруулах, танилцуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.05-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Тус тендерт шалгарч гэрээ байгуулсан "И-Эм Технологи" ХХК-ийн зөвлөх багийн эцсийн тайланг хүлээн авч гэрээг дүгнэж, төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | **100** | ТХГН-ийн онцлог, хүн байгаль, биологийн олон янз байдлын зөв зохистой харилцааг олон нийтэд түгээх, байгаль орчны доройтол, түүнд тулгамдаж буй асуудал, байгаль хамгаалагчийн ажлын онцлог, тулгамдаж буй асуудал, төслийн үйл ажиллагаа, зорилго зорилтыг олон нийтэд таниулах, түгээх, сурталчлах , мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэсэн. |
| **ҮАТ 4.06** ЮНЕСКО-гийн Дэлхийн өв, Хүн ба шим мандлын нөөц газарт бүртгүүлэх ТХГН-ийн тухай контент, баримтат кино бүтээх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.06-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ оны 01 дүгээр сарын 11-ний өдөр "Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг" НҮТББ-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Гэрээлэгчийн эцсийн тайлантай Ажлын хэсэг танилцаад зөвшөөрсөн тул төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийг гэрээлэгчийн дансанд шилжүүлэхээр ажиллаж байна. Хэрэгжилт 100% | **100** | Монголын говийн хосгүй үнэ цэнийг харуулсан ховор содон амьтан, ургамал, байгалийн төрх онцлог зэргийг багтаасан 3 минут үргэлжлэх богино хэмжээний цуврал 5 контентуудыг Монгол хэл дээр (Англи хадмалтай) хүлээж авах мөн ЮНЕСКО-ийн Дэлхийн Өвд бүртгүүлэхээр ажиллаж буй тусгай |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хамгаалалттай газрууд, тэдгээрийн хосгүй үнэ цэнийг харуулсан цуврал нэвтрүүлэг хийх нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 4.07** ТХГН-ийн менежментийг бэхжүүлэх зорилготой гадаад, дотоодын сургалтын аялал зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.07-д батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. Хэрэгжилт 0%. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 4.08** ТХГН-ийн мэдээллийн сангийн сүлжээ серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.08-д батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан бөгөөд энэ онд “Ай Ти Зон” ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг хангаж ажиллалаа. Сервер компьютер-1 ширхэг, Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж-2 ширхэг, Тог баригч – 1 ширхэг, Программ хангамж: VMWare vSphere, Microsoft Windows сервер, Active Directory, Domain control, GPO, Үйлчилгээ: Тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, цахилгааны болон сүлжээний холболт, тохируулгыг бүрэн хийж хүлээлгэн өгч, хэрэглэгч болон аюулгүй ажиллагааны болон мэдээлэл технологийн мэргэжилтэнд зориулсан холбогдох сургалтыг зохион байгуулсан тул төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт өмч хөрөнгийг шилжүүлж бүртгэл үүсгэсэн. | 100 | Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын мэдээллийн аюулгүй байдал хангагдаж, дотоод үйл ажиллагааг цахимжуулан, мэдээллийг нэгдсэн стандартад оруулж, цахим архив үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 4.09** Монгол орны ТХГН-ийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.9-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтаар амжилттай зохион байгуулсан. Тендерт шалгарсан “Битсофт” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 10-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээлэгч эхлэлийн тайлан хүлээлгэж өгснөөр төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эхний санхүүжилтийн 40 хувийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. Хэрэгжилт 100% | 100 | Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас (*www.mpa.gov.mn*) болон 41 хамгаалалтын захиргааны цахим хуудсыг шинэчлэн холбогдох мэргэжилтнүүдэд зориулсан цахим хуудсыг ашиглах, мэдээлэл оруулах, засварлах, устгах |

| | | | |
|---|---|---|---|
| | | | талаарх сургалтыг зохион байгуулж чадавхжуулах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **ҮАТ 4.10** ХЗ-нд нийлүүлсэн хөрөнгөд хяналт-шинжилгээ хийх, хариуцсан мэргэжилтнүүдэд төслийн мониторингийн сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.10-1 батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 4.11** Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөлийн хурал зохион байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 4.9-д батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь төслөөс зохион байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээгээр хийгдсэн ажлын үр дүнгийн тайланг БОАЖЯ /Хуучин нэршлээр/-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/65 тушаалаар батлагдсан мэргэжлийн зөвлөлөөр жил бүр хэлэлцүүлэн авдаг тогтсон зарчмын дагуу энэхүү төсөл, арга хэмжээ 2024 онд ч мөн үргэлжлэн хийгдлээ. | 100 | Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөл нь төслөөс зохион байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний хүрээнд хийгдсэн суурь судалгааны арга зүйн тайланг хэлэлцэн үнэлж, мэргэжлийн дүгнэлт гарган, үр дүнг тооцон Захиалагчид тайлагнан зөвлөмж өгч ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. |

**ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН 11 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ/ БИЕЛЭЛТ**

- **ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ БАГ /ТЗБ/:** Үйл ажиллагааны төлөвлөгөөний гуравдугаар зорилтын хүрээнд ТЗБ-ийн хийсэн ажлын хэрэгжилт 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:
- *ҮАТ 4.3, 4.7 болон 4.10-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 0%;*
- *ҮАТ 4.2, 4.4, 4.5, 4.6, 4.8, 4.9, болон 4.11-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 100%;*

- **ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ /ТХН/**: "Ажлын даалгавар хүлээлцэх хуваарь"-ийн төлөвлөсөн хугацаанаас хоцроож ирүүлсэн 2 ажлын даалгаврын дагуу тендер шалгаруулалтыг явуулж, гэрээ байгуулж, холбогдох сургалтын зохион байгуулж, он дамжсан болон энэ онд байгуулагдсан гэрээний санхүүжилтийг олгосноор гуравдугаар зорилтын хэрэгжилт 77,7 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Тайлбар: Төсөл, арга хэмжээний ажлын даалгавруудыг хугацаа хоцроож ирүүлснээс шалтгаалж ажил хоцрогдолтой хэрэгжсэн. Мөн ажлын даалгаврыг огт ирүүлээгүй нь тендер шалгаруулалтыг эхлүүлэх боломжгүй болгосон. ТХН-ийн зүгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд шаардлага, албан бичиг хүргүүлж, хурал уулзалт зохион байгуулан ажилласан.*

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ "ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛТ"-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 73,6 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭНД

| Төсөл, арга хэмжээний нэр | Хэрэгжилт, түүний явц | Хэрэгжилтийн хувь | Хүрсэн үр дүн |
|---|---|---|---|
| **ҮАТ 5.1** ОБ-ийн амьжиргааг дэмжихэд зориулсан БОНН-ийн урьдчилсан үнэлгээ/үнэлгээ, тухайн барилгын БОНМТ боловсруулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 5.1-т батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь ҮАТ 2.20 Баруун бүсийн хог хаягдлын менежментийн хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах болон ҮАТ 2.21 Хяргас нуурын БЦГ-ын (Увс аймгийн Завхан сум) орчны бүсэд перевоз барих хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах ажилтай уялдан шаардлагатай тохиолдолд БОННМТ хийхээр төлөвлөгдсөн. Энэ хүрээнд *ESM*-ийн баг Хог хаягдлын менежментийн төслийн ТЭЗҮ-д болон, Очны бүсийн сан, Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлэх талаар зорилтот газруудад дээр очиж ажилласан. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 5.2** ҮАТ-нд тусгагдсан ажлуудад БОНМ урьдчилсан үнэлгээ/үнэлгээ, БОНМТ/БОНМЗ боловсруулах | Тус ажил нь ҮАТ 2.18 Ховд аймагт Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих болон 2.19 Байгаль хамгаалагчийн байр барих ажилтай уялдан шаардлагатай тохиолдолд БОННМТ болон БОННҮАТ хийхээр төлөвлөгдсөн. Энэ хүрээнд Эрээн нуурын ЕМ-ийн төлөвлөгөө хийгдсэн. Говийн ДЦГ-ын Б хэсгийн барилгын ESMP-төлөвлөгөө хийгдсэн ба Байгаль Хамгаалагчдын байрны хувьд ажил эхлээгүй байгаа учраас *ESMP* шаардлагагүй гэдэг дүгнэлт гарсан. | 0 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хүрэх дүнд хүрч хэрэгжээгүй байна. |
| **ҮАТ 5.3** Эрээн нуурын нөхөн сэргээлтийн ажлын БОНН-ийн урьдчилсан үнэлгээ тухайн | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 5.3-т батлагдсан тус төсөл, арга хэмжээ нь Тендерийн ажлын даалгаврыг боловсруулахад шаардлагатай мэдээллийг | 100 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай хамтран ажилласнаар Эрээн хуурын нөхөн сэргээлтийн ажлын |

| | | | |
|---|---|---|---|
| барилгын БОНМТ боловсруулах | 3Г-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай хамтран гаргаж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Говь-Алтай аймгийн Хөх морьт сумд ажилласны дагуу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр оролцогч талуудын хамтарсан хурлыг зохион байгуулж, 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хөрсний дээжийг шинжилгээнд өгсөн. Барилгын ажил гүйцэтгэгч "Усны эрчим" ХХК-тай хийсэн Усны газрын ажлын гэрээг орчуулж Донорт танилцууллаа. | | гүйцэтгэгч "Усны эрчим" ХХК-тай хийсэн гэрээний үнэ болох 841,000,000.0 төгрөгийг Монголын талын хөрөнгө оруулалтад KfW тооцоохоор боллоо. |

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ "БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТ"-ИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 33,3 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА**

| ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ БОЛОН ЗӨВЛӨХ БАГИЙН ЗАРДАЛ | | | |
|---|---|---|---|
| **Төсөл, арга хэмжээний нэр** | **Хэрэгжилт, түүний явц** | **Хэрэгжилтийн хувь** | **Хүрсэн үр дүн** |
| **ҮАТ 6.01**<br>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан хэрэгцээнд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 6.1-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтаар амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан "Амугэ" ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд нийлүүлэх барааг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр ажлын хэсэг ажиллаж, актаар барааг хүлээн авсан. Гэрээлэгчийн эцсийн тайлантай Ажлын хэсэг танилцан хүлээж авсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | 100 | Төсөлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааны хэвийн тогтвортой ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлсэн. |
| **ҮАТ 6.02**<br>БОЯБХУАӨДЗ Төслийн цахим хуудсыг шинэчлэх, мониторингийн мэдээллийн сан байгуулах | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 6.2-т батлагдсан тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулсан. Тендерт шалгарсан | 100 | Төсөл хэрэгжүүлэгч талууд болон оролцогч нарт цаг үеийн чанартай мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, таниулах, сурталчлах мэдээ, мэдээллээр |

| | | | |
|---|---|---|---|
| | "Идеадэвэлопмент" ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг энэ онд хангаж ажиллалаа. Гэрээний хүрээнд хийгдсэн ажил үйлчилгээтэй Ажлын хэсэг танилцан хүлээж авсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | | хангах нөхцөл бүрдүүлж, холбогдох төрийн байгууллагуудын цахим хуудастай мэдээлэл солилцох бололцоог хангагдаж, төслийн мониторингийн цахим сан бүрдэх нөхцөлийг хангасан. |
| **ҮАТ 6.03**<br>Төслийн 2023 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 6.3-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. "Интераудит" ХХК-тай 2023 онд байгуулсан гэрээний дагуу төслийн I болон II, III шатны 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, Үндэсний аудитын газар хүргүүлсэн. | **100** | Аудитын тайлан хүлээн холбогдох байгууллагуудад хүргүүлж, танилцуулсан. |
| **ҮАТ 6.04**<br>Төслийн 2024 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 6.3-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. 2024 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайланд аудит хийх гэрээг "Мишээл Од" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 26-ны байгууллаа. | **100** | Гэрээ байгуулагдсан бөгөөд холбогдох талуудад хүргүүлсэн. |
| **ҮАТ 6.05**<br>Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний 6.5-д батлагдсан тус төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтаар амжилттай зохион байгуулагдсан. Тендерт шалгарсан "Дабль Эл" ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээлэгчийн эцсийн тайлантай Ажлын хэсэг танилцан хүлээж авсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу гэрээний эцсийн төлбөрийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн. | **100** | Захиалагчаас хүлээлгэн өгсөн Төслийн тусгай гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтүүд болон Санхүүжилтийн гэрээг Ажлын даалгаварт заасан заасан хугацаан дотор *MNS ISO 17100:2015* стандартад нийцсэн орчуулгыг хүлээлгэн өгсөн. |

| | | | |
|---|---|---|---|
| **ҮАТ 6.06**<br>Төслийн зөвлөх багийн төлбөрийн | 2020 онд БОАЖЯ "Eco Консалт Сепп ба Бусакер, Gitec-Igip" зөвлөх компанитай байгуулсан гэрээний нэмэлт гэрээний дагуу 2023 оны сүүлийн хагас жилийн санхүүжилт ҮАТ-нд заасан үнийн дүнгээр Германы сэргээн босголт зээлийн (KfW) банкнаас 2024 оны 01 дүгээр сард шилжсэн болно. | **100** | Төлбөрийг шилжүүлсэн. |

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ "ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ БОЛОН ЗӨВЛӨХ БАГИЙН ЗАРДАЛ"-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 100 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

| **ТАЙЛАН** | | | |
|---|---|---|---|
| **Төсөл, арга хэмжээний нэр** | **Хэрэгжилт, түүний явц** | **Хэрэгжилтийн хувь** | **Хүрсэн үр дүн** |
| **R01**<br>Хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж БОУАӨЯ, СЯ-д хүргүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний R.01-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг тухай бүр нь хуулийн хугацаанд мэдээлэн ажилласан. | **100** | - Санхүүгийн ерөнхий тайлан;<br>- НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна.<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж байна.<br>- Хүн амын орлогын албан татварын тайланг сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст хүргүүлж байна.<br>Сангийн яамны PIMIS системд мэдээллээ тухай бүр нь оруулж ажилласан. |
| **R02**<br>Улирал, хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг KfW банканд илгээх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний R.02-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг тухай бүр нь хуулийн хугацаанд мэдээлэн ажилласан. | **100** | Төслийн үйл ажиллагааны тайланг улирал тутамд KfW-банканд тайлагнасан. |
| **R.03**<br>Тусгай дансны татан авалт, зарцуулалтын | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний R.03-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг цаг | **100** | Тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг KfW банканд илгээснээр Тусгай |

| | | | |
|---|---|---|---|
| тайланг KfW банканд илгээх | хугацаанд нь Донорт мэдээлж ажилласан. | | дансны татан авалтаа хийсэн. |
| **R.04**<br>Шилэн данс, *ODAMIS*, www.shilen-dans.mn, *E-Report*, *E-tailan*-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх | Үйл ажиллагааны төлөвлөгөө /ҮАТ/-ний R.04-т батлагдсан тус төсөл, арга хэмжээг тухай бүр нь хуулийн хугацаанд мэдээлэн ажилласан. | **100** | - Сангийн яамны PIMIS системд мэдээллээ тухай бүр нь оруулж ажилласан.<br>- Худалдан авах ажиллагааны явцын тайланг сар бүрийн 25-ны өдөр БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж ажилласан. Худалдан авах ажиллагааны улирлын тайлан, хагас жилийн тайлан болон жилийн эцсийн тайланг БОУАӨЯ болон Сангийн яаманд хулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан.<br>- Шилэн дансанд оруулах байгууллагын мэдээллийг тухай бүр нь хуулийн хугацаанд нь оруулж, нийтэд ил тодоор мэдээлэн ажилласан.<br>- Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирлаар, хагас жилээр, жилийн эцсийн байдлаар Захиалагчид хүргүүлсэн.<br>Төслийн хяналт шинжилгээ үнэлгээний тайланг хагас жилийн байдлаар Захиалагчид хүргүүлсэн. |

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ "ТАЙЛАН"-ИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ 100 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

| ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | |
|---|---|---|---|
| № | Үйл ажиллагааны төрөл | Хэрэгжүүлсэн ажлын дундаж хувь | Тайлбар |
| 1 | Төслийн нэгдүгээр зорилт | 67,6 | БОУАӨЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III” төслийн 2024 үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон дүгнэхэд **70,8** хувийн биелэлттэй байна. |
| 2 | Төслийн хоёрдугаар зорилт | 60,6 | |
| 3 | Төслийн гуравдугаар зорилт | 60,9 | |
| 4 | Төслийн дөрөвдүгээр зорилт | 73,6 | |
| 5 | Байгаль орчин, нийгмийн менежмент | 33,3 | |
| 6 | Төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн зардал | 100 | |
| 7 | Тайлан | 100 | |

ТАНИЛЦСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА, ТӨСЛИЙН ЗАХИРАЛ — Д.БАТЦОГТ

ХЯНАСАН:

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II/III” ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ — М.БОЛДБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН — Ч.ОЮУНБИЛЭГ

ТӨСЛИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛТАН — М.САНААЖУУ

ТӨСЛИЙН ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛТАН — Б.ДЭЛГЭРМАА